



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/28/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2025 он	ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Аудитыг гүйцэтгэсэн: "Бэйкэр Тилли Далайван аудит" ХХК Утас: 99396969 Цахим хаяг: <a href="mailto:urtaa6969@gmail.com">urtaa6969@gmail.com</a>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15-17
4. Аудитын тайлан	17-20
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. Аудитын илрүүлэлт	19-20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	21-22

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БЕГ	Боловсролын ерөнхий газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НА	Нийцлийн аудит
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТАГ	Төрийн аудитын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОУБ	Олон улсын байгууллага



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

МАНДАЛ СУМЫН  
ТҮНХЭЛ ТОСГОНЫ ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Д.ЭНХТУЯА ТАНАА

2025. 02. 25 № СЭА-2025/28-НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тус сургууль нь Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 2 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 39,842.8 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

### Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус сургуулийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 9 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 92 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 95.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>149,396,691.82</b>	<b>212,962,989.24</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>122,588,739.65</b>	<b>204,736,591.84</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>122,588,739.65</b>	<b>204,736,591.84</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>122,588,739.65</b>	<b>204,736,591.84</b>
31211	Төрийн сангийн харилцах	122,588,739.65	204,736,591.84
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>92,672.16</b>	<b>0.00</b>
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	92,672.16	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>26,715,280.01</b>	<b>8,226,397.40</b>
351	Түүхий эд материал	<b>14,799,038.61</b>	<b>6,159,842.40</b>
3511	Тусгай зориулалттай материал	14,479,038.61	5,959,842.40
3513	Эм боох материал	320,000.00	200,000.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>11,916,241.40</b>	<b>2,066,555.00</b>
3541	Бичиг хэргийн материал	815,300.00	277,500.00
3542	Аж ахуйн материал	1,164,450.00	1,132,600.00
3545	Барилгын засварын материал	21,400.00	0.00
3546	Хүнсний материал	3,612,950.00	0.00
3547	Бусад хангамжийн материал	6,302,141.40	656,455.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,053,653,652.18</b>	<b>1,105,855,973.38</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,053,653,652.18</b>	<b>1,105,855,973.38</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,016,019,203.46</b>	<b>1,068,241,399.66</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	809,053,829.25	809,053,829.25
39202	Хуримтлагдсан элэгдэл	(130,749,575.31)	(177,617,447.67)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,562,500.00	14,562,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(13,680,729.51)	(14,441,145.83)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	313,382,736.09	453,546,654.09
39206	Хуримтлагдсан элэгдэл	(138,761,104.91)	(183,109,862.58)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	119,635,897.15	141,974,119.15
39208	Хуримтлагдсан элэгдэл	(50,746,611.04)	(67,639,387.55)
39214	Бусад үндсэн хөрөнгө	74,228,105.00	74,228,105.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(27,200,760.03)	(33,120,576.27)
39217	Ном	46,294,916.77	50,804,612.07
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>37,634,448.72</b>	<b>37,614,573.72</b>
39301	Програм хангамж	318,000.00	318,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(183,551.28)	(203,426.28)
39303	Бусад биет бус хөрөнгө	37,500,000.00	37,500,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,203,050,344.00</b>	<b>1,318,818,962.62</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>171,600.05</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	171,600.05
413	Өглөг	0.00	171,600.05
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	171,600.05
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,203,050,344.00</b>	<b>1,318,647,362.57</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,203,050,344.00</b>	<b>1,318,647,362.57</b>

51100	Засгийн газрын оруулсан капитал	407,571,022.70	407,571,022.70
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	0.00	0.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>414,901,643.78</b>	<b>530,498,662.35</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	414,901,643.78	414,901,643.78
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	115,597,018.57
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	380,577,677.52	380,577,677.52
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,203,050,344.00</b>	<b>1,318,818,962.62</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН	
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,312,135,293.11</b>	<b>2,030,134,729.78</b>	
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>25,319,579.70</b>	<b>135,481,862.70</b>	
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>25,319,579.70</b>	<b>135,481,862.70</b>	
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>25,319,579.70</b>	<b>5,469,600.00</b>	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	0.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,866,200.00	200,000.00	
120009	Бусад орлого	0.00	200,000.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	11,260,713.00	125,687,820.30	
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	9,192,666.70	4,124,442.40	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,286,815,713.41</b>	<b>1,894,652,867.08</b>	
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,191,923,000.00</b>	<b>1,802,951,400.00</b>	
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,191,923,000.00	1,802,951,400.00	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,019,888.00</b>	<b>0.00</b>	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,019,888.00	0.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>93,872,825.41</b>	<b>91,701,467.08</b>	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	93,872,825.41	91,701,467.08	
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,333,213,807.70</b>	<b>1,914,537,711.21</b>	
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,333,213,807.70</b>	<b>1,914,537,711.21</b>	
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,251,104,507.70</b>	<b>1,825,222,201.21</b>	
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>934,728,479.40</b>	<b>1,338,309,402.53</b>	
210101	Үндсэн цалин	648,707,782.21	879,264,885.06	
210102	Нэмэгдэл	245,860,148.27	395,136,114.42	
210104	Урамшуулал	40,160,548.92	63,908,403.05	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>84,673,555.14</b>	<b>164,902,356.06</b>	
210201	Тэтгэврийн даатгал	62,713,538.64	113,299,093.30	
210202	Тэтгэмжийн даатгал	5,677,376.39	13,648,193.64	

210203	ҮОМШӨ-ний даатгал	4,511,060.87	6,794,396.80
210204	Ажилгүйдлийн даатгал	1,070,143.60	6,232,074.47
210205	Эрүүл мэндийн даатгал	10,701,435.64	24,928,597.85
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>82,980,225.41</b>	<b>81,808,867.08</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,224,559.84	8,644,966.20
210302	Түлш, халаалт	69,917,685.57	69,627,570.88
210303	Цэвэр, бохир ус	3,837,980.00	3,536,330.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
210408	Бараа материал акталсны зардал		
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
210502	Хоол, хүнс		
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,892,600.00</b>	<b>9,899,600.00</b>
210604	Урсгал засвар	10,892,600.00	9,899,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,608,700.00</b>	<b>29,569,308.43</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,866,200.00	3,473,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,742,500.00	26,095,908.43
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>127,220,947.75</b>	<b>200,732,667.11</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,964,656.81	67,519,753.01
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,447,048.00	18,403,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	78,809,242.94	114,809,514.10
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>82,109,300.00</b>	<b>89,315,510.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>82,109,300.00</b>	<b>89,315,510.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	58,802,500.00	62,620,310.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,306,800.00	26,695,200.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-21,078,514.59</b>	<b>115,597,018.57</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-21,078,514.59</b>	<b>115,597,018.57</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,291,681,913.41</b>	<b>1,900,522,467.08</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,866,200.00</b>	<b>5,869,600.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>4,866,200.00</b>	<b>5,869,600.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>4,866,200.00</b>	<b>5,669,600.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,866,200.00	0.00
120009	Бусад орлого	0.00	200,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,286,815,713.41</b>	<b>1,894,652,867.08</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,191,923,000.00</b>	<b>1,802,951,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,191,923,000.00	1,802,951,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,019,888.00</b>	<b>0.00</b>

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,019,888.00	0.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>93,872,825.41</b>	<b>91,701,467.08</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	93,872,825.41	91,701,467.08
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,254,590,686.92</b>	<b>1,818,374,614.89</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,254,590,686.92</b>	<b>1,818,374,614.89</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,168,768,886.92</b>	<b>1,733,469,454.89</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>907,537,846.08</b>	<b>1,338,216,730.37</b>
210101	Үндсэн цалин	621,802,924.93	879,172,212.90
210102	Нэмэгдэл	245,574,372.23	395,136,114.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	40,160,548.92	63,908,403.05
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>111,956,860.62</b>	<b>164,730,756.01</b>
210201	Тэтгэврийн даатгал	76,712,757.74	114,195,499.58
210202	Тэтгэмжийн даатгал	9,039,298.21	12,580,187.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,224,201.28	6,794,396.80
210204	Ажилгүйдлийн даатгал	1,725,482.23	6,232,074.47
210205	Эрүүл мэндийн даатгал	17,255,121.16	24,928,597.85
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>82,980,225.41</b>	<b>81,808,867.08</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,224,559.84	8,644,966.20
210302	Түлш, халаалт	69,917,685.57	69,627,570.88
210303	Цэвэр, бохир ус	3,837,980.00	3,536,330.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,892,600.00</b>	<b>9,892,600.00</b>
210604	Урсгал засвар	10,892,600.00	9,892,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>12,745,700.00</b>	<b>35,854,708.43</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,866,200.00	5,669,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,879,500.00	30,185,108.43
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>42,655,654.81</b>	<b>102,965,793.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,058,806.81	87,028,593.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,596,848.00	15,937,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>85,821,800.00</b>	<b>84,905,160.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>85,821,800.00</b>	<b>84,905,160.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	62,515,000.00	59,007,360.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,306,800.00	25,897,800.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>37,091,226.49</b>	<b>82,147,852.19</b>

IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	51,771,780.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	51,771,780.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	51,771,780.00	0.00
222001	Тоног төхөөрөмж	35,531,780.00	0.00
223001	Бусад хөрөнгө	16,240,000.00	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(51,771,780.00)	0.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(14,680,553.51)	82,147,852.19
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		122,588,739.65
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		204,736,591.84

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	407,571,022.70	380,577,677.52	436,079,708.37	1,224,228,408.59
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
7	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-21,178,064.59	-21,178,064.59
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	407,571,022.70	380,577,677.52	414,901,643.78	1,203,050,344.00
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
17	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	115,597,018.57	115,597,018.57
19	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	407,571,022.70	380,577,677.52	530,498,662.35	1,318,647,362.57

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,994,045,900.00</b>	<b>1,818,374,614.89</b>	<b>175,671,285.11</b>	91.2
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,994,045,900.00</b>	<b>1,859,698,629.89</b>	<b>134,347,270.11</b>	93.3
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,896,421,500.00</b>	<b>1,774,793,469.89</b>	<b>121,628,030.11</b>	93.6
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,457,235,500.00</b>	<b>1,338,216,730.37</b>	<b>119,018,769.63</b>	91.8
210101	Үндсэн цалин	939,816,300.00	879,172,212.90	60,644,087.10	93.5
210102	Нэмэгдэл	451,239,400.00	395,136,114.42	56,103,285.58	87.6
210104	Урамшуулал	66,179,800.00	63,908,403.05	2,271,396.95	96.6
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>182,154,500.00</b>	<b>164,730,756.01</b>	<b>17,423,743.99</b>	90.4
210201	Тэтгэврийн даатгал	123,865,100.00	114,195,499.58	9,669,600.42	92.2
210202	Тэтгэмжийн даатгал	14,572,300.00	12,580,187.31	1,992,112.69	86.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,286,200.00	6,794,396.80	491,803.20	93.3
210204	Ажилгүйдлийн даатгал	7,286,200.00	6,232,074.47	1,054,125.53	85.5
210205	Эрүүл мэндийн даатгал	29,144,700.00	24,928,597.85	4,216,102.15	85.5
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>96,101,500.00</b>	<b>81,808,867.08</b>	<b>14,292,632.92</b>	85.1
210301	Гэрэл, цахилгаан	13,200,000.00	8,644,966.20	4,555,033.80	65.5
210302	Түлш, халаалт	78,581,500.00	69,627,570.88	8,953,929.12	88.6
210303	Цэвэр, бохир ус	4,320,000.00	3,536,330.00	783,670.00	81.9
2105	<b>Нормативт зардал</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	
210502	Хоол, хүнс	0.00	0.00	0.00	
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,892,600.00</b>	<b>9,892,600.00</b>	<b>0.00</b>	100.0
210604	Урсгал засвар	9,892,600.00	9,892,600.00	0.00	100.0
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>43,172,700.00</b>	<b>35,854,708.43</b>	<b>7,317,991.57</b>	83.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,669,600.00	5,669,600.00	0.00-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	37,503,100.00	30,185,108.43	7,317,991.57	80.5
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>107,864,700.00</b>	<b>144,289,808.00</b>	<b>(36,425,108.00)</b>	133.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	91,909,500.00	128,352,608.00	(36,443,108.00)	139.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,955,200.00	15,937,200.00	18,000.00	99.9
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>97,624,400.00</b>	<b>84,905,160.00</b>	<b>12,719,240.00</b>	87.0
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>97,624,400.00</b>	<b>84,905,160.00</b>	<b>12,719,240.00</b>	87.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	71,726,600.00	59,007,360.00	12,719,240.00	82.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,897,800.00	25,897,800.00	0.00-	100.0
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>-41,324,015.00</b>	<b>41,324,015.00</b>	
	Дотоод эх үүсвэрээр	0.00	-41,324,015.00	41,324,015.00	
222001	Тоног төхөөрөмж	0.00	-41,324,015.00	41,324,015.00	
1	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ</b>	<b>2,036,316,600.00</b>	<b>1,900,522,467.08</b>	<b>135,794,132.92</b>	93.3

	<b>ҮҮСВЭР</b>				
<b>131</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,036,116,600.00</b>	<b>1,894,652,867.08</b>	<b>141,463,732.92</b>	93.1
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,930,122,500.00	1,802,951,400.00	127,171,100.00	93.4
	Орон нутгийн төсөв	105,994,100.00	91,701,467.08	14,292,632.92	86.5
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>200,000.00</b>	<b>5,669,600.00</b>	<b>(5,469,600.00)</b>	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	0.00	0.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	0.00	200,000.00	0.0
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		122,588,739.65	0.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		204,736,591.84	0.00	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мандал сумын Түнхэл тосгоны ерөнхий боловсролын сургууль нь “Уншсанаа ойлгон цэгцтэй ярьдаг, эерэг зөв хүндлэлтэй, эрүүл шүдтэй хүүхэд болон төлөвшинө” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сурагчдын сурлагын хоцрогдлыг бууруулах, сургалтыг тэгш хүртээмжтэй хүргэх,
- Эх хэлээрээ зөв сайхан найруулан ярих чадварыг хөгжүүлэх
- Зөв дадал хэвшүүлэх аян арга хэмжээг тогтмол зохион байгуулах
- Эрүүл мэндийн боловсролын дээшлүүлэх
- Өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмолжуулж үр дүнг тооцох

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын Түнхэл тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мандал сумын Түнхэл тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 115,768.7 мянган төгрөгөөр буюу 8.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	122,588.7	204,736.6	82,147.9
Авлага	92.7		(92.7)
Бараа материал	26,715.3	8,226.4	(18,488.9)
Үндсэн хөрөнгө	1,053,653.6	1,105,856.0	52,202.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,203,050.3</b>	<b>1,318,819.0</b>	<b>115,768.7</b>
Өр төлбөр		171.6	171.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,203,050.3	1,318,647.4	115,597.1
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,203,050.3</b>	<b>1,318,819.0</b>	<b>115,768.7</b>

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 204,736.6 мянган төгрөг болж 82,147.9 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Авлага дансны үлдэгдэл 92.7 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг барагдуулснаас,
- Бараа материал дансны үлдэгдэл 8,226.4 мянган төгрөг болж 18,488.9 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 115,946.2 мянган төгрөгийн бараа материал бэлтгэн, БЕГ-с 4,124.4 мянган төгрөгийн ном үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 138,559.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл */анхны өртгөөр/* 1,581,987.8 мянган төгрөг болж 167,011.9 мянган төгрөгөөр өссөн нь Боловсролын яамнаас 108,286.0 мянган төгрөгийн ном, зөөврийн компьютер, ширээ сандал, Дезерет ОУБ-с 17,401.9 мянган төгрөгийн зөөврийн компьютерыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 41,324.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч, 114,809.5 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцоноос тус тус шалтгаалсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 2,074,232.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 93,187.6 мянган төгрөг нийт 2,167,419.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин, НДШ-ийн зардлыг 548,586.9 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 36,969.6 мянган төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардлыг 74,667.0 мянган төгрөгөөр нийт 660,223.5 мянган төгрөгөөр бууруулж нийт төсвийг 1,507,196.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд 9 удаа төсвийн зохицуулалт хийгдэж цалин, НДШ-ийн зардлыг 423,764.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 8,285.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 34,757.2 мянган төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардлыг 7,237.1 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 12,806.5 мянган төгрөгөөр нийт 486,849.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн улсын төсвөөс 1,765,263.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 105,994.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 200.0 мянган

төгрөг, урьд оны үлдэгдлээс 122,588.7 мянган төгрөгийг зарцуулахаар төсвийг нийт **1,994,045.9** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу нийт 1,994,045.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 1,818,374.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,818,374.6 мянган төгрөг буюу 91.2 хувьтай байгаа нь үдийн цайны зардлыг 12,719.2 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны зардлыг 162,952.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

							<i>/мянган төгрөгөөр/</i>	
д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
1	71802 Ерөнхий боловсрол	1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	3,984.3	3,984.3	-	100.0	
		2	80233-Хүүхэд хамгаалал	4,117.4	4,117.4	-	100.0	
		3	80312- Сургалт семинар	2,820.2	2,820.2	-	100.0	
		4	81605- Эрүүл мэндийг дэмжих	3,984.3	3,984.3	-	100.0	
		5	81801- Үдийн цай хөтөлбөр	71,726.6	59,007.4	12,719.2	82.3	
		7	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	30,335.8	30,335.8	-	100.0	
		8	81823- Боловсролын багшийн сургалт	12,091.0	7,020.0	5,071.0	58.1	
		9	81834- Боловсролын стандарт сургалт	1,635,553.7	1,502,426.5	133,127.2	91.9	
		10	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	111,510.1	104,151.1	7,359.0	93.4	
		11	81875-Сургуулийн нэмэлт хөтөлбөрийг хэрэгжүүлэх	6,058.8	2,956.6	3,102.2	48.8	
		12	81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	200.0	200.0	-	100.0	
		13	81848-Сурах бичгийн түрээс	5,669.6	5,669.6	-	100.0	
		14	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	105,994.1	91,701.5	14,292.6	86.5	
		<b>Нийт</b>				<b>1,994,045.9</b>	<b>1,818,374.6</b>	<b>175,671.4</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

#### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайлант худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулан хоол хүнсний 64,489.5 мянган төгрөгийн, бараа үйлчилгээний бусад зардалд 67,733.0 мянган төгрөгийн гүйцэтгэгч бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтыг 3 удаа зарласан боловч гүйцэтгэгч ирээгүй учраас хоол хүнсийг “Энгмаа” ХХК, Г.Намжил нартай шууд гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

#### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мандал сумын Түнхэл тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор Ц.Уртнасан, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын ерөнхий боловсролын Түнхэл тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг гүйцэтгэлийг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ний Дархан салбарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,333,313.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 13,333.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт:**

Мандал сумын ерөнхий боловсролын Түнхэл тосгоны ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд :**

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын

2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар багш нарт шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэлгүйгээр 1,215.7 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоож, худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулах, үндсэн хөрөнгийн тооллогын баримтыг бүрэн гүйцэд бүрдүүлэх цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн төлбөрийн акт, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

*Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	1,215.7	1	1,215.7	100.0
Зөвлөмж	2	-	2	-	100.0
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>1,215.7</b>	<b>3</b>	<b>1,215.7</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох дараах 11,420.6 мянган төгрөгийн алдааг бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой залрууллаа. Үүнд:

- Үр дүнгийн тайланд хандиваар ирсэн 3,473.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 200.0 мянган төгрөгийг орлогыг дутуу тусгасан,
- Цалингийн зардлыг 3,622.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Бараа материалын тайланд хандиваар ирсэн 4,124.4 мянган төгрөгийн хөрөнгийг тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт **4,177.4** мянган төгрөгийн зөрчил илэрснээс 4,177.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах 1 зөвлөмж хүргүүлээ.

#### 5.1 Төлбөрийн акт

1. Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүй, аймгийн түвшинд амжилт гаргасныг нотлох баримтгүйгээр 18 багшид 20 хувиар тооцон /өмнөх онд гүйцэтгэлийн үнэлгээгээр II түвшинд үнэлэгдсэн гэж/ 2,323.2 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Боловсрол шинжлэх

ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан "Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай" тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь "Энэхүү баримт бичгийн 4,5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60.0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараах хувиар тогтооно. "цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10 хувь" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон үр чадварын нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. Тухайн төсвийн дээд шатны захирагчийн шийдвэрээр бус сумын Засаг даргын 2024 оны 02 дугаарын сарын 01-ний өдрийн 01/86 дугаар захирамжаар нягтлан бодогч Р.Цээпил, нярав С.Болортуяа нарын үндсэн цалинг 25 хувиар нэмэгдүүлэн 1,854.2 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ": 14.2.3 дахь "Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 128 дугаар тогтоолын 2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

## 5.2 Зөвлөмж

**Аудитаар дараах зөрчлийг давтан гаргахгүй ажиллах зөвлөмж өглөө.**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 2.1 Зардлын данстай холбоотой асуудал

2.1.1 Илрүүлэлт: Нийгмийн даатгалын тайланд хүүхдээ асарч буй багшийн шимтгэлийг 6 сар ажилласнаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2.1.2 Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтад үндэслэн НДШ-ийн тайланг үнэн зөв гаргах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>1</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг

<sup>1</sup> Шалгадагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр дүнгийн тайланд орлого дутуу тусгасан	1	200.0	1	200.0			1	200.0				
Үр дүнгийн тайланд хөрөнгө дутуу тусгасан	1	3,473.4	1	3,473.4			1	3,473.4				
Бараа материалын тайланд орлого буруу тусгасан	1	4,124.4			1	4,124.4	1	4,124.4				
Үр дүнгийн тайланд цалингийн зардал дутуу тусгасан	1	3,622.8	1	3,622.8			1	3,622.8				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>11,420.6</b>	<b>3</b>	<b>7,296.2</b>	<b>1</b>	<b>4,124.4</b>	<b>4</b>	<b>11,420.6</b>				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин илүү олгосон	1	4,177.4	1	4,177.4								
Нийгмийн даатгалын тайланд цалин илүү тайлагнасан	1						1					
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>4,177.4</b>	<b>1</b>	<b>4,177.4</b>			<b>1</b>					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
<b>Нийт дүн</b>	<b>1</b>						<b>1</b>	<b>-</b>

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.